

**ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХАМТ ӨРГӨН  
МЭДҮҮЛСЭН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЗӨРЧЛИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН АНХНЫ  
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХИ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2017 оны 04 дүгээр  
сарын 18-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Л.Болд**

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Хууль зүйн байнгын хороо 2017 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 21.3 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцлээ.

Байнгын хороогоор дээрх асуудлыг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар Эрүүгийн хуульд шинээр оруулж байгаа гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдийг төсөлд тодорхойгүй, хэт өрөнхий заасан нь хүн, хуулийн этгээдийг ял завшуулах, эсхүл тэдгээрийн эрхийг нь зөрчих үндэслэл болох тул хуулийн төсөлд гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдийг тодорхой тусгах, мөн дээрх эрүүгийн хэрэгт оногдуулах ялын интервалыг уялдаа холбоотойгоор дүйцүүлэх шаардлагатай зэргийг үндэслэн хуулийн төслийн талаар холбогдох зарчмын зөрүүтэй саналуудыг гаргаж хураалгасан.

Түүнчлэн, хууль санаачлагч 2015 онд батлагдсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулахаар хуулийн төсөл өргөн мэдүүлсэн байна. Гэтэл Засгийн газар уг хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай гэж үзэж 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд Хууль зүйн байнгын хорооны анхны хэлэлцүүлгийн шатанд байгаа болно.

Иймд Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй нийцүүлэх нь зүйтэй гэж тус Байнгын хорооны гишүүд үзэж байсан болно.

Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаархи Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг нэгтгэн томьёолж, Та бүхэнд тараасан байгаа.


Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаархи Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**

**Ш.РАДНААСЭД**



# **ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХИ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

## **Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал:**

**1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

**“1 дүгээр зүйл. 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 18.17 дугаар зүйл нэмсүгэй:**

**“18.17 дугаар зүйл. Үндэсний төлбөрийн системийн үйл ажиллагааг хууль бусаар эрхлэх**

**1. Үндэсний төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн, эсхүл төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хасаж зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.**

**2. Үндэсний төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн, эсхүл төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийг хуурч, эсхүл хуурамч баримт бичиг бүрдүүлэн авсны улмаас бусдын эд хөрөнгө, эдийн, эдийн бус хөрөнгийн эрхэд ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.**

**3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэж бусдад гурван зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээний хохирол учруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.**

**4. Энэ зүйлд заасан гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.**

**5. Энэ зүйлд заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”**

**2. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

**“2 дугаар зүйл. Энэ хуулийг Үндэсний төлбөрийн системийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.”**

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар**

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Х.НЯМБААТАРААС ГАРГАСАН  
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 18.17 дугаар зүйл нэмсүгэй:**

**“18.17 дугаар зүйл.Үндэсний төлбөрийн системийн үйл ажиллагааг  
хууль бусаар эрхлэх**

1. Үндэсний төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн, эсхүл төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хасаж зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Үндэсний төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн, эсхүл төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийг хуурч, эсхүл хуурамч баримт бичиг бүрдүүлэн авсны улмаас бусдын эд хөрөнгө, эдийн, эдийн бус хөрөнгийн эрхэд ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэж бусдад гурван зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээний хохирол учруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ зүйлд заасан гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5. Энэ зүйлд заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

2. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.Энэ хуулийг Үндэсний төлбөрийн системийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”**

**Улсын Их Хурлын гишүүн**

**X.Нямбаатар**